# “ТЕРРА ВИСТА” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “ШАРАНГАТАЙ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(Регистрийн дугаар – 5968216)

**ХЯНАСАН:**

ХБОБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

**БОЛОВСРУУЛСАН:**

“ТЕРРА ВИСТА” ХХК

ЗАХИРАЛ Г.ГАНБАГАНА

“ТЕРРА ВИСТА” ХХК

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН О.АЗЗАЯА

ТЕРРА ВИСТА ХХК
TERRA VISTA Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ
1115205061 5968216

**УЛААНБААТАР 2024 ОН**

# ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ........ 8
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ........ 10
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 13
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 20
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 22
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 23
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 23
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 24
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 27
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 29
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 39
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 43

**Хүснэгтийн жагсаалт**


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд....................3
Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим....................5
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .......13
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт....................20
Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....................22
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт....................24
Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ....................27
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний биелэлт....................29
Хүснэгт 9. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн....................35
Хүснэгт 10. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн....................36
Хүснэгт 11. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн ....................36
Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүн ....................37
Хүснэгт 13. Усны химийн шинжилгээний дүн ....................38
Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ....................39
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт....................43


**Зургийн жагсаалт**


Зураг 1. Төслийн байршлын зураг....................3
Зураг 2. 2024 оны уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажил....................6
Зураг 3. 2024 оны тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээ ....................6
Зураг 4. 2024 оны тэсрэх бүтээгдэхүүн үйлдвэрлэл ....................7
Зураг 5. Тоног төхөөрөмжийн жагсаалт ....................7

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** "Шарангатай" хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл

**Төсөл хэрэгжүүлэгч: "**Терра виста" ХХК

**Төслийн байршил:** MV-022056 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий хайлуур жоншны ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын 4-р багийн нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос урагш 312 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос урагш 70 км, Өлзийт сумаас баруун хойш 40км зайд байрлана.

*Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд*

| Цэгийн дугаар | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|
| | X | Y |
| 1 | 106° 2' 10.58" | 45° 11' 30" |
| 2 | 106° 2' 10.58" | 45° 11' 26.8" |
| 3 | 106° 2' 33.7" | 45° 11' 26.8" |
| 4 | 106° 2' 33.7" | 45° 11' 24.02" |
| 5 | 106° 1' 59.26" | 45° 11' 22.16" |
| 6 | 106° 1' 47.26" | 45° 11' 1.32" |
| 7 | 106° 1' 44.9" | 45° 11' 1.32" |
| 8 | 106° 1' 44.9" | 45° 11' 40" |
| 9 | 106° 2' 33.7" | 45° 11' 40" |
| 10 | 106° 2' 33.7" | 45° 11' 30" |




*Зураг 1. Төслийн байршлын зураг*

**Ордыг ашиглах тусгай зөвшөөрөл:** Ашигт Малтмал Газрын Тосны Газрын Кадастрын хэлтсийн даргын 2021 оны 12 сарын 28-ний өдрийн 505 тоот шийдвэрээр Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байрлах MV-022056 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Шарангатай" хайлуур жоншны ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2051 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хүртэл 30 жилийн хугацаатай "Терра виста" ХХК-д олгосон байна.

**Ашиглалтын систем:** Ордын уул-техникийн нөхцөл, хүдрийн биетийн геологийн тогтцыг харгалзан ил аргаар, экскаватор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй, гадаад болон гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.

Доголын өндөр: Хүдрийн хаягдал бохирдлыг бага байлгах, хүдрийн биетийн цул тогтцоос хамааруулан уурхайн ажлын доголын өндрийг $H_д$=5м байхаар тооцов. Доголын өндөр бага байснаар хүдэр хөрсний чулуулгийн зааг орчимд үүсэх хаягдал болон бохирдлын хэмжээ багасах нөхцөл бүрдэнэ.

Ажлын бус доголын өндөр: Уурхайн ажлын доголыг цаашид ашиглахгүй, ил уурхайн хүрээ хязгаарт хүрсэн үед ажлын доголуудыг нэгтгэн ажлын бус догол үүсгэнэ. Ажлын бус доголын өндөр 10м байна.

Ажлын доголын хажуугийн налуугийн өнцөг: Ажлын доголын хажуугийн налуугийн өнцгийг чулуулгийн шинж чанарын нөхцөлөөр тодорхойлоход хөрс, хүдрийн доголд $\alpha_д=60^0$ байна. Шинээр ашиглалтын түвшин нээхэд огтлох траншейгаар нээнэ. Траншей нээх, ажиллах техникийн аюулгүй зайн нөхцөлөөр ажлын талбай тодорхойлогдоно. Ажлын хамгийн бага өргөн 25 м-ээс багагүй байна.

Хэвийн ажлын талбайн өргөн нь доголын ахилтын хурд (нөөц орлын тоо), дээд доголын тоогоор тодорхойлогдоно.

- Доголын ирмэгээс аюулгүйн зурвасын өргөн- 3.0м
- Автомашины тэнхлэгээс дээд доголын хормой хүртэлх зай –3м
- Хөдөлгөөний зурвасуудын тэнхлэг хоорондох зай - 3м

*Хүснэгт 1. Ашиглалтын технологи*

| Технологи | Үндсэн ажил | Технологийн процессууд |
|---|---|---|
| Тээвэртэй ашиглалтын технологи | Хөрс хуулалт | Өрөмдлөг тэсэлгээ<br>Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Овоолох |
| | Олборлолт | Өрөмдлөг тэсэлгээ<br>Ухаж ачих<br>Тээвэрлэх<br>Овоолох |

**Уурхайн тээвэр**

Дотоод тээвэр: Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд дунджаар 80.0 мян.м$^3$ хөрс хуулж, 40 мян.тн хүдэр олборлоно.

а. Хөрс тээвэрлэлт. Хөрсийг уурхайн дотор явах замын дундаж зайг оруулан дунджаар 0.9 км зайнд байрлах гадаад овоолгод тээвэрлэнэ.

б. Хүдрийн дотоод тээвэр. Жилд дунджаар 15.4 мян.м$^3$ буюу 40.0 мян.тн хүдрийг мөргөцгөөс шууд ачиж, хүдэр буулгах талбай хүртэл тээвэрлэнэ. Уурхай дотоод тээвэрт Howo 25 маркийн автосамосвалыг ашиглана.

Гадаад тээвэр: "Шарангатай"-н уурхайн бутлан ангилах хэсгээс гарах баяжмалыг Чойр өртөө хүртэл 220 км зайд 35 тн-ын даацтай автосамосвлалаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрээр уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний тээвлэх маршрутын дагуу тээвэрлэнэ.

**Уулын ажлын горим:** Уулын ажил нь жилд 8 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 1 ээлжээр 10 цагаар явагдана.

Туслах ажлууд болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг зэрэг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

*Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим*

| Үзүүлэлт | Х.нэгж | Хоног |
|---|---|---|
| Календарь хоног | хоног | 180 |
| Жилд ажиллах сар | сар | 6 |
| Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |
| Ээлжийн тоо | ээлж | 1 |
| Баяр ёслолын хоног | хоног | 10 |
| Цаг агаарын саатал | хоног | 8 |
| Бэлтгэл ажлын хоног | хоног | 2 |
| Жилд ажиллах хугацаа | хоног | 160 |

**2024 оны уулын ажлын төлөвлөгөө:**

"Терра виста" ХХК-ийн MV-022056 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Шарангатай" хайлуур жоншны ордын 2024 оны уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажил:

**Ашигт малтмал газрын тосны газар**

**Маягт-9.1**

Аж ахуйн нэгжийн нэр: Терра виста
Ашигт малтмалын төрөл: Хайлуур жонш
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022056

Баяжуулалтын технологи:,Гар ялгалт
Төлөвлөгөөний он:2024
Тухайн онд боловсруулах хүдрийн (элс) хэмжээ:30.00

**Уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажил**

| Д/д | Тусгай зөвшөөрлийн дугаар, огноо | | Өрөмдлөгийн хэмжээ (мян.тууш.м) | | | Нийт уулын цул мян.м³ | | Тэслэгдэх уулын цулын хэмжээ мян.м³ | | | Агуулахын багтаамж (тн) | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тэсэлгээ | Тэсэлгээний туслан гүйцэтгэгч | Хөрс | Хүдэр | Нийт өрөмдлөгийн хэмжээ | Хөрс | Хүдэр | Хөрс | Хүдэр | Нийт уулын цулын хэмжээ | Агуулахын ангилал | Тэсрэх бодис | Тэсэлгээний хэрэгсэл | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 1 | №174, 2018-02-20 | МОНТРЕКС ХХК | 11.5 | 1.2 | 12.7 | 90.2 | 10.489510489510 | 90.2 | 10.48951048951049 | 100.6895104895105 | Байнгын | 15 | | |

*Зураг 2. 2024 оны уурхайн өрөмдлөг, тэсэлгээний ажил*

"Терра виста" ХХК-ийн MV-022056 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Шарангатай" хайлуур жоншны ордын 2024 оны тэсрэх бодис, тэсэлгээний ажил:

**Ашигт малтмал газрын тосны газар**

**Маягт-9.2**

Аж ахуйн нэгжийн нэр: Терра виста
Ашигт малтмалын төрөл: Хайлуур жонш
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022056

Баяжуулалтын технологи: ,Гар ялгалт
Төлөвлөгөөний он: 2024
Тухайн онд боловсруулах хүдрийн (элс) хэмжээ: 30.00

**Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээ**

| Д/д | Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл | Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээ | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нэр, төрөл | Хэмжих нэгж | Орлого | Зарлага | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Тэсрэх бодис | АНФО | тн | 86.125 | 86.125 | |
| 2 | Тэсрэх бодис | ЭМУЛЬС | тн | 21.537499999999998 | 21.537499999999998 | |
| 3 | Тэсэлгээний хэрэгсэл | НОНЕЛЬ | ш | 1250 | 1250 | |
| 4 | Тэсэлгээний хэрэгсэл | ӨДӨӨГЧ | ш | 625 | 625 | |
| 5 | Тэсэлгээний хэрэгсэл | Цочир дамжуулах шижим | м | 3125 | 3125 | |
| 6 | Тэсэлгээний хэрэгсэл | Хором удаашруулагч | ш | 125 | 125 | |
| 7 | Тэсэлгээний хэрэгсэл | Тэслүүр | ш | 62.5 | 62.5 | |

*Зураг 3. 2024 оны тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэглээ*

"Терра виста" ХХК-ийн MV-022056 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Шарангатай" хайлуур жоншны ордын 2024 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв:

**Ашигт малтмал газрын тосны газар**

**Маягт - 1.1**

Аж ахуйн нэгжийн нэр: Терра виста
Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022056
Ашигт малтмалын төрөл: Хайлуур жонш
Баяжуулалтын технологи: ,Гар ялгалт

Төлөвлөгөөний он:2024
ТЭЗҮ-ээр ашиглах нийт хугацаа:5
Ашиглалтын хэд дэх жил:2

**Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөв**

| № | Нөөцийн зэрэг | | Бүтээгдэхүүний хэмжээ | | | Ашигт малтмалын нэр | Агуулга | | | Металл (эрдэс)-ын хэмжээ | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хэмжих нэгж | Тоон утга | Экспорт | | Хэмжих нэгж | Тоон утга | Экспорт | Хэмжих нэгж | Тоон утга | Экспорт | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 2025 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ | | | | | | | | | | | | |
| | | Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ | мян.тн | 30.00 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 43.10 | | мян.тн | 12.93 | | |
| | | 1 Бүхэллэг жонш ФК-80 | мян.тн | 8.11 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 78.90 | | мян.тн | 6.40 | | |
| | | 2 Хайлуур жоншны хүдэр ФР | мян.тн | 21.89 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 29.84 | | мян.тн | 6.53 | | |
| 2 | 2026 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ | | | | | | | | | | | | |
| | | 2 Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ | мян.тн | 35.00 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 42.90 | | мян.тн | 15.02 | | |
| | | 1 Бүхэллэг жонш ФК-80 | мян.тн | 9.46 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 78.90 | | мян.тн | 7.46 | | |
| | | 2 Хайлуур жоншны хүдэр ФР | мян.тн | 25.54 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 29.56 | | мян.тн | 7.55 | | |
| 3 | 2027 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ | | | | | | | | | | | | |
| | | 2 Боловсруулах хүдэр (элс)-ийн хэмжээ | мян.тн | 37.00 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 42.80 | | мян.тн | 15.84 | | |
| | | 1 Бүхэллэг жонш ФК-80 | мян.тн | 10.00 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 78.90 | | мян.тн | 7.89 | | |
| | | 2 Хайлуур жоншны хүдэр ФР | мян.тн | 27.00 | | 1 Хайлуур жонш (CaF2) | % | 29.43 | | мян.тн | 7.95 | | |

Төлөвлөгөө гаргасан: Амарбаясгалан
Ерөнхий инженер: Амарбаясгалан
Баяжуулагч инженер:

Хүлээн авсан:
Мэргэжилтэн: Х.Лхагвабаатар

***Зураг 4. 2024 оны тэсрэх бүтээгдэхүүн үйлдвэрлэл***

“Терра виста” ХХК-ийн MV-022056 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Шарангатай” хайлуур жоншны ордын тоног төхөөрөмжийн жагсаалт:

**Ашигт малтмал газрын тосны газар**

**Маягт-8**

Аж ахуйн нэгжийн нэр: Терра виста
Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022056
Ашигт малтмалын төрөл: Хайлуур жонш

Баяжуулалтын технологи:,Гар ялгалт
Төлөвлөгөөний он:2024
Тухайн онд боловсруулах хүдрийн (элс) хэмжээ:30.00

**Уурхайн олборлолтын тоног төхөөрөмжийн жагсаалт**

| Д/д | Тоног төхөөрөмжийн нэр | | | | Хүчин чадал баталгаа | | Ашиглалтын хугацаа | | | Цахилгаан зарцуулалт | Түлш зарцуулалт | | | | Өмчлөлийн хэлбэр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Марк | Төрөл | Загвар | Үйлдвэрлэсэн улс | Нэгж | Хэмжээ | Үйлдвэрлэсэн он | Ашиглалтад өгсөн он | Ашиглалтын хугацаа | Суурилагдсан чадал кВт (kW) | Хэмжих нэгж | Зарцуулалтын тоон утга | Нийт ажиллах гүйлт (мото/цаг) | Нийт зарцуулах түлшний хэмжээ | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 1 | HYUNDAI | Экскаватор | R480LC-9 | БНСУ | м3 | 2.7 | 2016 | 2021 | 10 | 266 | мото/цаг | 25 | 1920.00 | 48000.00 | Өөрийн | |
| 2 | HOWO | Автосамосвал | SINOTRUCK ZZ3317N2861 | БНХАУ | м3 | 16 | 2020 | 2022 | 10 | 273 | нэг.км | 0.35 | 13600.00 | 4760.00 | Өөрийн | |
| 3 | HOWO | Автосамосвал | SINOTRUCK ZZ3317N2861 | БНХАУ | м3 | 16 | 2020 | 2022 | 10 | 273 | нэг.км | 0.35 | 13600.00 | 4760.00 | Өөрийн | |
| 4 | SHANTUI | Бульдозер | SD23 | БНХАУ | м3 | 250 | 2019 | 2022 | 10 | 280 | мото/цаг | 35 | 1200.00 | 42000.00 | Өөрийн | |
| 5 | XCMG | Утгуурт ачигч | ZL50F | БНХАУ | м3 | 3 | 2019 | 2022 | 10 | 250 | мото/цаг | 30 | 1600.00 | 48000.00 | Өөрийн | |
| | НИЙТ | --- | --- | --- | --- | --- | --- | --- | 50.00 | --- | --- | --- | --- | 147,520.00 | --- | --- |

Төлөвлөгөө гаргасан: Амарбаясгалан
Ерөнхий инженер: Амарбаясгалан
Баяжуулагч инженер: Амарбаясгалан

Хүлээн авсан:
Мэргэжилтэн:

***Зураг 5. Тоног төхөөрөмжийн жагсаалт***

# 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Физик газарзүйн нөхцөл:** Тус бүс нутаг нь физик газарзүйн мужлалаар Говийн их болон Дорнод говийн мужийн Дорноговийн хотгор, Умард говийн ухаа толгодот талын тойрогт хамаарах ба байгалийн бүсийн ангиллаар хээржүү цөлийн бүсэд, Умард говийн гүвээт-Халхын дундад талын гадаргын усны сав газрын ангилалд хамаарна.

Ашигт малтмал ашиглалтын талбай, түүний орчмын нутаг нь Дундговь аймгийн төвөөс урагш, Өлзийт сумын хойд хэсгийг хамран хээр ба говийн их мужийн шилжилтийн заагаар орших бөгөөд цав толгодлог, ухаа гүвээт гэсэн 2 төрлийн рельф зонхилдог.

Цав толгодлог рельфийн үнэмлэхүй өндөр нь баруунаас зүүн урагшлах тутам аажим намсах ба ихэвчлэн бөмбөгөрдүү оройтой налуу хажуутай байдаг. Боржин болон дэл судлын чулуулаг тархсан газар янз бүрийн хэлбэртэй цохионууд ажиглагдана.

Мөлгөрдүү ухаа гүвээт талархаг рельф нь цэрд, юрагийн хурдас тархсан нутгуудаар голлон байрлана. Харьцангүй өндөр нь 10-30м байдаг. Ийм төрлийн рельф нь гуу жалгаар харьцангуй бага хэрчигдсэн. Маш налуу хажуутай толигор оройтой бөгөөд, цав толгодлог рельфтэй хяр хэцүүдтэй ихэвчлэн налуу хажуугаар хааяа мөргөцгөөр тусгаарлагдана. Чулуулгийн гарш, илэрц нь толгодын хажуу хормой, хааяа оройн хэсгээр тохиолдоно.

**Хөрс, хөрсөн бүрхэвч:** Тал, газар хөндий хотгорын хүрэн хөрс тархана. Энэ хэвшинжийн хөрс Монгол орны тал хээр, уулсын хоорондох хөндий хотгорт өргөргийн ба хотгорын бүс, дэд бүсүүд үүсгэж дорнод хэсэгт 600-700 м-ээс өрнөд хэсэгт 2300-2400 м хүртэл үнэмлэхүй өндөрт хамгийн түгээмэл тархсан байна. Ургамал бүрхэвчид нь үетэнт, агь-үетэнт, алаг өвс-үетэнт хуурай хээрийн ба заримдаа цөлөрхөг хээрийн ургамалшил зонхилж, харгана байнга тааралдана. Газрын дээрх ургамлын массын ( фитомассын ) хэмжээ 6-27 ц/га, газрын доорхи нь 170-400 ц/га хүрдэг.

Хүрэншороон хөрсний профиль дараах үе давхаргуудаас тогтоно: A-B-BCa-BCCa-CCa.

Ялзмаг хуримтлалын давхарга (A) нь бараан хүрэн, хүрэн, цайвар хүрэн өнгөтэй, өнгөнийх нь байдал ялзмагийн хуримтлалтай шууд холбоотой, бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй, жижиг сайр чулуу бараг байнга агуулсан байдаг, доод хил нь тод ялгарч зааглагддаг, зузаан нь янз бүр, 10 см-ээс 30-35 см хүртэл хэлбэлзэнэ.

Шилжилтийн ялзмагт (B) давхарга тод бор, цайвар бор өнгөтэй, бусад давхаргуудаас арай хурц туяатай, нягтавтар, хил зааг нь тод, зузаан нь 10-25 см заримдаа эртний

цэвдгийн ан цаваар доошоо 40-80 см хүртэл хошуурч орсон байна. Энэ давхарга хархүрэн, хүрэн хөрсөнд байхаас цайвар хүрэн хөрсөнд А давхаргын доор шууд карбонатын (BCa ) давхарга оршино.

**Ургамлан нөмрөгийн төлөв байдал:** Цөөннаст алаг өвс болох толгодын бударгана, монгол өвс-таанат (*Allium polyrrhizum, A.mongolicum, Stipa gobica, Cleistogenes squarrosa*) ургамалжил зонхилж, олон наст үетэн говийн хялгана болон дэрвээн хазаар өвс дэд зонхилогч, цөөннаст үетэн болох алтан харгана, бага хургалж, ямаан шарилж дагалдах бөгөөд ордын толгодорхог хэсгээр экологийн бүлгийн хуурайсаг элементүүд болох говийн хялгана, алтан харгана, ямаан шарилж, бага хургалж зэрэг зүйлүүд бүртгэгдсэн.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

**Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

Уурхайн тээвэрлэлтийн үед үүсэх тоосжилт:

- Хүдрийн овоолгын уусгалт
- Хүдэр овоолох талбай
- Уурхайн гадаад тээвэрлэлт
- Техник тоног төхөөрөмжийн дуу чимээ

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

**Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

Уурхайн олборлолтын болон бусад төрлийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн эх үүсвэр нь:

Ордын ашиглалтын хугацаанд ордын барилга байгууламж барих бүтээн байгуулалтын үед хөрсөн бүрхэвч ихээр талхлагдана. Цаашлаад үйл ажиллагааны явцад засвар үйлчилгээ, ШТМ агуулах, ахуйн хог хаягдал зэргээс хөрс бага зэрэг бохирдох

**Гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй. Үүнд:

- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг борхирдуулах
- Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах

- Уурхайн байгууламж, хоосон овоолго, хаягдлын сан, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магадлалтай.

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг арга хэмжээнүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.

Мөн Монгол улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" болон "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" зэргийг удирдлага болголоо.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг ажлууд багтсан бөгөөд 8.740 сая.төг зарцуулахаар төсөвлөсөн байна.

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

*Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжилт | Тайлбар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, - Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй | Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх | Бүрэн хэрэгжсэн | Уурхайн үйл ажиллагааны үед бороо ороогүй, салхи ихтэй, тоосжилт дэгдсэн үеүдэд зам талбайн усалгааг хийж гүйцэтгэсэн. |   |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох | Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт сурталчилгаа явуулах | Бүрэн хэрэгжсэн | Төслийн хугацаанд уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах амны маск болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүдээр ажилчдыг хангаж ажилласан. |  |
| 3 | | Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх | Бүрэн хэрэгжсэн | Уурхайн ажлын явцад ашиглагдаж буй машин механизмд үзлэг шалгалтыг хийж шаардлага хангахгүй машин механизмыг талбайд гаргахгүйгээр ажилласан. |  |
| 4 | Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, | Асгаралтын үе хэрэглэх багаж хэрэгслээр хангаж ажиллах | Бүрэн хэрэгжсэн | ШТС-ын бүтээгдэхүүн асгарахаас сэргийлэн ШТС-ыг бетон хучилттайгаар байгуулж, ажилчдад мэдээлэлээр хангаж ажилласан. |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах | Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалах зорилгоор ажилчид болон машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах, авто зогсоолыг тэмдэгжүүлэх | Бүрэн хэрэгжсэн | Техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах тэмдэг тэмдэглэгээ болон авто зогсоолын талбайд тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. |        |
| 6 | | Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах | Бүрэн хэрэгжсэн | Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг стандарт, төлөвлөгөөний дагуу цэгцтэйгээр байршуулсан. |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | |  |
| 7 | Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд | Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх | Бүрэн хэрэгжсэн | 2024 оны 12 сарын 31 өдөр Усны тжхай хуулийн 29.1-д заалт Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 11 сарын 01-ний өдрийн А/192 тоот захирамжийг үндэслэн гэрээ хийсэн байна. |  |

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 12 сарын 31-ний өдөр Дугаар Рашаант

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 29.1-д заалт Дундговь аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 35 тоот дүгнэлт, Засаг даргын 2024 оны 12 сарын 27-ны өдрийн А/ тоот захирамжийг үндэслэн ус ашигпуулагчийг төлөөлж Өлзийт сумын Засаг дарга А.Жавхлан УБ хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Төгөл хус 12-1 тоот хаягтай 9011554003 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5968216 тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Өлзийт сумын 4-р багт Шарангатай нэртэй талбайд ашиглалтын MV-022056 тусгай зөвшөөрөл эзэмшигч "Терра виста" ХХК-ны захирал Гомбосүрэн овогтой Ганбагана нар энэхүү гэрээг 6 сарын хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Усны эх үүсвэрийн мэдээлэл

2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт: "Терра виста" ХХК нь "Шарангатай" хайлуур жоншны ордын хүдэр олборлолтын талбайд ил аргаар жонш олборлоно.
2.2 Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:
Тус компани нь 43 хүний бүрэлдэхүүнтэйгээр 180 хоног ажиллана. Хөрс хуулалт болон олборлолтын ажилд экскаватор, автосамосвал, Hanjin-16BT маркийн өрмийн машин, ZL50F модел ачигч, SD маркийн бульдозер зэрэг машинууд тус тус ажиллана. /2024 оны уулын ажлын төлөвлөгөө, БОМТ/
2.3 Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ: 2024 оны уулын ажлын төлөвлөгөө, БОМТ-нд тусгагдсаны дагуу 2024 онд 40мян.тн баяжмал олборлох.
2.4 Усны эх үүсвэр, нөөц хоногт ашиглах хэмжээ: Тус уурхайн унд ахуйн болон зам талбайн тоосжилт дарах усаа Баруун булаг нэртэй гүний өрмийн худгаас ашиглана. Худгийн гүн-62м, түвшин -10м, ундарга-2.5мл/с.
2.5 Усны барилга байгууламжууд нэр, хүчин чадал, хэмжээ, хийц дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/: Баруун булаг гүн өрмийн нь 2х2 харьцаатай блокон байшинтай. Ус дамжуулах хоолойн диаметр 50мм, 5 метр урт
2.6 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2024 онд "Теам смайл" ХХК гүйцэтгэсэн.
2.7 Онцгой нөхцөл: Гүн өрмийн худаг гаргах
2.8 Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох: Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаал, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327, дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны төлбөрийг тооцвол нийт 888000/найман зуун наян найман мянган төгрөг/-ний усны төлбөрийг Дундговь аймгийн төрийн сан банкны 100080000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5,10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
4.2. Ус ашигпуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
4.5. Гэрээг доор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.
4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хамгаалалтад шилжсэн
4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол.
4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
ДУНДГОВЬ АЙМАГ ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
/А.ЖАВХЛАН/
Утас: 88887527

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
ТЕРРА ВИСТА" ХХК-НЫ ЗАХИРАЛ
........................../Г.ГАНБАГАНА/
Утас:99009348

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | сөргөөр нөлөөлж болзошгүй. | Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт) | Бүрэн хэрэгжсэн | Галын сараа, гал түймэртэй тэмцэх багаж хэрэгслүүдийг авч шаардлагатай газруудад байршуулсан. |     |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | | Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдваргүйжүүлэлт | Бүрэн хэрэгжсэн | Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэсэн. |   |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | <br> |

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Тайлбар | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | Төсөл хэрэгжүүлэгч "Терра виста" ХХК нь ашигт малтмал эрэл-хайгуулын шатнаас эхлэн орон нутгийн удирдлагуудтай уулзаж сургуулийн тохижилт, хашаа хайс будах, өвөлжилтийн бэлтгэл ажил зэрэг ажлуудыг сумын иргэдтэй хамтран ажиллаж ирсэн билээ. Тус ордыг ил уурхайн аргаар ашиглах бөгөөд нөхөн сэргээлтийн ажлын сум орон нутгаас санал авсан дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр шийднэ. | Өлзийт сумын 100 жилийн ойн /наадам/ үйл ажиллагаанд нэг үе дансанд 20.000.000 төгрөг байршуулсан. |  |

TransBank

Шилжүүлгийн мэдээлэл:
Журнал дугаар: 897090020044

Гүйлгээний огноо: 07/23/2024 13:57:07

| | | | Дүн | Ханш |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар MN710019009110000475 | Нэр ТҮШИГТ-ЭЭЛ ХХК | 10,000,000.00 MNT | 1.0 |
| Хүлээн авагч | Банкны нэр Хаан банк Дансны дугаар 5085829272 | Нэр ӨЛЗИЙТ НЭГ ҮЕ | 10,000,000.00 MNT | 1.0 |

Гүйлгээний утга:
Терра виста ХХК-с наадам 100 жилд

Шимтгэлийн мэдээлэл: БАЙГУУЛЛАГЫН БАНК ХООРОНДЫН БЭЛЭН БУС ШИЛЖҮҮЛГИЙН ШИМТГЭЛ: 500MNT
Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан:
Салбар,тооцооны төв:
Гарын үсэг:
Тамга:

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх | Бүрэн хэрэгжсэн |   |

# 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | Хэрэгжилт | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Орон нутгийн удирдлагуудтай уулзаж сургуулийн тохижилт, хашаа хайс будах, өвөлжилтийн бэлтгэл ажилд тусалсан.<br>1 айлд хarааны шороо зөөж өгсөн.<br>1 айлд хороо хийх чулуу, шороо зөөж өгсөн. |   |

## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл аж иллагаа хийгдэхгүй тул 2024 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

## 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Терра виста” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд палеонтлогийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулна.

# 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

